

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД
ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Үндсэн хуульд доор дурсан агуулгатай дараахь зүйл, хэсэг нэмсүгэй.

1/Арван ес¹ дүгээр зүйл:

“Арван ес¹ дүгээр зүйл

1. Нам нь нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодлын үүднээс сайн дураар эвлэлдсэн, нэгдмэл, тодорхой үзэл санааны хүрээнд улс төрийн үйл ажиллагаа явуулж, төрийн бодлогыг тодорхойлох зорилготой Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн.

2. Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий тавин мянга нэгээс доошгүй тооны иргэн нэгдэж байгуулах бөгөөд гишүүний бүртгэл, өөрчлөлтийг сонгуулийн төв байгууллага хөтөлнө.

3. Намын дотоод зохион байгуулалт нь ардчилсан зарчимд нийцсэн байна. Намын удирдлага болон удирдах дээд байгууллагын сонгуулийг сонгуулийн төв байгууллага, дотоод бусад сонгуулийг холбогдох сонгуулийн байгууллага хариуцна.

4. Нам үл хөдлөх болон ахуйн хэрэгцээнийхээс бусад үнэ бүхий хөдлөх хөрөнгө өмчлөхгүй. Намын орлогын эх сурвалж, зарцуулалт нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагаа, санхүүжилт, ил тод байдал болон төрөөс дэмжлэг үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно.”

2/Арван ес² дүгээр зүйл:

“Арван ес² дүгээр зүйл

1. Монгол Улс төв банкттай байна. Төв банк нь хараат бус, бие даасан байгууллага байх бөгөөд Монголбанк гэж нэрлэнэ.

2. Монголбанк нь төрийн мөнгөний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах болон санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлж, төрийн эрдэнэсийн санг эрхлэн удирдана.

3. Монголбанкны үйл ажиллагааны эрх зүйн үндэсийг хуулиар тогтооно.

3/Зургадугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“6.Нийтийн өмчийн газрыг Монгол Улсын иргэнд өмчлүүлэх, иргэн, хуулийн этгээдэд тодорхой хугацаагаар эзэмшүүлэх буюу ашиглуулах шийдвэрийг хуульд заасан болзол, журмын дагуу зөвхөн Засгийн газар, аймаг, хот, нийслэлийн Засаг дарга /Захирагч/ гаргана.”

4/Гучин есдүгээр зүйлийн 4, 5, 6, 7, 8 дахь хэсэг:

“4.Засгийн газар Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон тогтвортой хөгжлийн бодлогод нийцсэн үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж бүрэн эрхийнхээ хугацаанд хэрэгжүүлнэ.

5.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэж буй эсэхийг Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөл хэлэлцэн шийдвэрлэнэ.

6.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлогод нийцэж буй эсэхэд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан, хараат бус байгууллага хяналт тавьж, дүгнэлтээ Улсын Их Хурлаар хэлэлцүүлнэ.

7.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан, бодлогын тогтвортой байдалд хараат бусаар хяналт тавих байгууллагын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

8.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон тогтвортой хөгжлийн бодлогыг Улсын Их Хурал батлах бөгөөд Ерөнхийлөгч, Засгийн газар, аймаг, хот, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлаас санал авах, хэлэлцэх, батлах журмыг хуулиар тогтооно.”

5/Дөчин зургадугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Төрийн жинхэнэ албан хаагч яамны Төрийн нарийн бичгийн дарга хүртэл дэвшин ажиллах эрхтэй бөгөөд шатлан дэвших, чадахуйн зарчимд үндэслэсэн сонгон шалгаруулалтын болзол хангасан Монгол Улсын иргэн Төрийн нарийн бичгийн даргад чөлөөтэй өрсөлдөнө. Төрийн нарийн бичгийн даргыг арван жилийн хугацаагаар томилно. Төрийн нарийн бичгийн даргыг хуульд заасан үндэслэлээр чөлөөлж, огцруулна.”

6/Дөчин есдүгээр зүйлийн 6, 7, 8 дахь хэсэг:

“6.Шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах зорилгоор Шүүхийн сахилгын хороо ажиллана.

7.Шүүхийн сахилгын хороо хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах, чөлөөлөх тохиолдолд саналаа томилсон эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх бөгөөд бусад шийтгэл ногдуулах шийдвэрийг бүрэн эрхийнхээ хүрээнд өөрөө гаргана.

8.Шүүхийн сахилгын хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.”

7/Жардугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Аймаг, хот, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргыг хуульд заасан үндэслэл, журмаар чөлөөлж, огцруулна. Сум, дүүргийн Засаг даргыг огцруулсан бол бүрэн эрхийн үлдсэн хугацаанд ажиллах Засаг даргыг аймаг, хотын Засаг дарга /Захирагч/ томилно.”

2 дугаар зүйл.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.” гэсний өмнө “Улсын Их Хурлын сонгуулийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу мажоритар болон пропорциональ тогтолцоогоор явуулна. Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэний сонгох эрхэд хууль бус аргаар нөлөөлөх буюу саад учруулах оролдлого, хуйвалдааныг Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт халдсан гэмт хэрэг гэж үзнэ” гэсэн нэг, хоёр дахь өгүүлбэр, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16-ийн “Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ;” гэсний дараа “Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх аливаа оролдлогыг үл зөвшөөрөх бөгөөд ийм санаархал бүхий ард нийтийн санал асуулга явуулахыг хориглоно;” гэсэн гурав дахь өгүүлбэр, Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ.” гэсний дараа “Ерөнхий сайд Улсын Их Хурлын гишүүн байх бөгөөд Засгийн газрын бусад гишүүд Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч үл болно.” гэсэн хоёр дахь өгүүлбэр, Жардугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ” гэсний дараа “Хотын Захирагч харьяалах нутаг дэвсгэртээ Засаг даргын үүргийг хавсран гүйцэтгэнэ.” гэсэн хоёр дахь өгүүлбэр, Жаран нэгдүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн “Засаг дарга” гэсний ард “/Захирагч/” гэж, Жаран хоёр дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “аймаг” гэсний ард “хот” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Монгол Улсын Үндсэн хуулийн дараахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг:

2.Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан нь нийтийн өмч мөн. Байгалийн баялагийг ашиглахдаа тэгш байдал, шударга ёс, үндэсний аюулгүй байдал,

тогтвортой хөгжлийг хангах зарчим баримтална. Газрын хэвлийн баялагийг төрөөс олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр Монгол Улсын хуулийн этгээдэд энэ зүйлд заасан зарчмын дагуу ашиглуулж болно. Онцгой ач холбогдол бүхий газрын хэвлийн баялагийг төр хамтран ашиглах тохиолдолд гарах зардлыг хөрөнгө оруулагч хариуцах бөгөөд татварын дараах ашгийн тавин нэгээс доошгүй хувь нь Монгол Улсын төрд ногдоно. Хөрөнгө оруулагчийн зардал бодитой байна. Хөрөнгө оруулагчийн зардалд төр хяналт тавьж ард түмэнд тайлагнана. Газрын хэвлийн баялагийг хөрөнгө оруулагчтай хамтран ашигласны орлогыг баялагийн санд төвлөрүүлж, зарцуулна. Байгалийн баялагийг ашиглах болзол, баялагийн сангийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

2/Арван гуравдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг:

“1.Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэж үзэх бөгөөд нийслэл нь хотод, хот нь дүүрэгт хуваагдана. Нийслэлийн хотын дүүргийг хороонд хувааж болно.

2.Нийслэл бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн бөгөөд эрх зүйн үндэсийг нь зөвхөн хуулиар тогтооно.”

3/Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун найман гишүүнээс бүрдэх бөгөөд тавин дөрвөн гишүүнийг нэг мандат бүхий сонгуулийн тойргоос мажоритар тогтолцоогоор, тавин дөрвөн гишүүнийг сонгуулийн нэгдсэн нэг тойргоос пропорциональ тогтолцоогоор тус тус сонгоно.”

4/Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно.”

5/Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, давж заалдах шатны шүүх, анхан шатны шүүхээс бүрдэнэ. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.”

6/Тавин долдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг:

“1.Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, хот, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, хот нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.

2.Аймаг, хот, сум, дүүргийн болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.”

7/Тавин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Аймаг, хот, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлыг таван жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно.”

8/Жардугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг:

“2.Аймаг, хот, нийслэлийн Засаг дарга /Захирагч/-ыг аймаг, хот, нийслэлийн Төлөөлөгчдийн хурлаас нэр дэвшүүлж Ерөнхий сайд; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус таван жилийн хугацаагаар томилно. Ерөнхий сайд аймаг, хот, нийслэлийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлд заасан журмаар дахин нэг удаа нэр дэвшүүлж Ерөнхий сайд томилно.

3.Сум, дүүргийн Засаг даргыг тухайн нутаг дэвсгэрийн иргэд таван жилийн хугацаагаар сонгож, аймаг, хотын Засаг дарга /Захирагч/ арван тав хоногийн дотор батламжилна. Сум, дүүргийн Засаг даргын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.”

9/Жаран гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Аймаг, хот, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурал эрх хэмжээнийхээ дотор тогтоол, Засаг дарга /Захирагч/ захирамж гаргана.”

4 дүгээр зүйл.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хорин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Дөчдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “дөрвөн” гэснийг “таван” гэж, Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.” гэснийг “Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайдаас бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.” гэж, Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн” гэснийг “хүн амын байршлыг үндэслэн гаргасан Засгийн газрын” гэж, Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Аймаг, нийслэл, сум, дүүрэг” гэснийг “Аймаг, хот, нийслэл, сум, дүүрэг” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Аймаг, нийслэл, сум, дүүргийн” гэснийг “Аймаг, хот, нийслэл, сум, дүүргийн” гэж, Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “аймаг, нийслэл, сум, дүүрэгт” гэснийг “Аймаг, хот, нийслэл, сум, дүүрэгт” гэж, Жаран нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба” гэснийг “Аймаг, хот, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга /Захирагч/-ын ажлын алба” гэж, Жаран хоёр дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад” гэснийг “Аймаг, хот, нийслэлийн Хурал, Засаг дарга

/Захирагч/-д" гэж, Жаран гуравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Засаг даргын" гэснийг "Засаг дарга /Захирагч/-ын" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёр дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "бие дааж" гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн 12 цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө.

---o0o---